

# Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах									
1		1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л				Байхгүй	Биеийн тамир, спортын улсын хорооны 39 000 дагагчтай фейсбүүк хуудас болон байгууллагын албан ёсны цахим хуудас sport.gov.mn веб сайтаар олон нийтэд авлигын эсрэг холбогдох мэдээллийг хүргэн ажиллаж байгаа ба тус мэдээлэл олон нийтийн сүлжээгээр 3560 хүнд хүрсэн байна. Мөн ЭБАТ мэдээлэл facebook сүлжээг мэдээлэл авах, сурталчлах зэргээр идэвхтэй ашиглаж байгаа болно. Авлигын эсрэг зурагт хуудас, 5 төрлийн гарын авлага, календарь, зурган наалт зэргийг албан хаагчдад тарааж, иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан. Авлигатай тэмцэх газрын youtube суваг IIAAC MONGOLIA-д орсон шторк, теле зохиомж, мэдээлэл зэргийг олон нийтэд хүргэх зорилгоор байгууллагын албан ёсны <a href="https://sport.gov.mn/">https://sport.gov.mn/</a> цахим сайтын ил тод байдал-авлигын эсрэг үйл ажиллагаа цэсэд <a href="https://www.youtube.com/channel/UCfX6_wN8B-Y16TYIfLdwQw/videos">https://www.youtube.com/channel/UCfX6_wN8B-Y16TYIfLdwQw/videos</a> сувгийг холбож өгсөн болно.	Хавсралт : 1 зураг	100%

		боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх.						
2		1.2. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.				16 000 000	Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/287 дугаар тушаалаар аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар /хороо/-ын дарга, нягтлан бодогч нарт Биеийн тамир, спортын салбарын “Төсөв, санхүүгийн шинэтгэл” сургалтыг зохион байгуулах, ажлын хэсэг байгуулах тухай тушаал гарсан. Энэхүү тушаалын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны Дэд дарга Ц.Одонбаяраар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Пума империал зочид буудлын хурлын танхимд зохион байгууллаа. Сургалтад аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар /хороо/-ын дарга, нягтлан бодогч Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн холбогдох албан тушаалтан зэрэг 70 гаруй албан хаагчид оролцсон бөгөөд zoom программаар аймаг, нийслэл, дүүргийн 32 байгууллагын албан хаагчид оролцлоо. Тус сургалт, хэлэлцүүлгийн 2 дахь өдрийн 14.00 цагаас Авлигаас урьдчилан сэргийлэх нь мэдээллийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга О.Баттулга хийж, сургалтын завсарлах цагаар "Зөв зөвд шударга зөв" шторкийг албан хаагчдад хүргэсэн болно.	100%
3		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.				800 000	Иргэд, олон нийтэл хүргэх мэдээллийг хүргэх зорилгоор байгууллагын мэдээллийн самбарыг шинэчлэн сайжруулж, Авлигатай тэмцэх газраас ирсэн урьдчилсан мэдүүлэг хянасан тухай албан бичгийг байгууллагын сайт болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулан ажилласан. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” тат, түлх стикерийг байгууллагын албан хаагчдын өрөөний хаалганд байршуулсан. Мөн энэ ажлын хүрээнд албан хаагчдын нэр, албан тушаалыг нэг загварт оруулан хаягжилтыг мэдээллийг шинэчилсэн.	70%

2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг сургалтад хамруулах								
4		2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-т хүргүүлж, албан хаагчдаа холбогдох сургалтад хамруулсан байх.				Байхгүй	Биеийн тамир, спортын улсын хорооны 8 чиг үүргийн төрийн захиргааны 37 албан хаагчийг Авлигын эсрэг сургалтад хамруулах санал хүргүүлж, сургалтын төлөвлөгөөнд тусгуулан албан хаагчдыг хамруулсан.	100%
5		2.2. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байдал.				16 000 000	Ковид цар тахлын үед Авлигын эсрэг сургалтыг Биеийн тамир, спортын салбарын удирдах ажилтнуудад танхимаар, аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газрын ажилтан албан хаагчдад ZOOM-ээр сургалтыг зохион байгуулсан сургалт 2021 оны 11 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан болно.	100%
3. Авлигатай тэмцэх газраас гаргасан шийдвэрийг биелүүлэх								
6		3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх.				Байхгүй	Биеийн тамир, спортын улсын хорооны WW.SPORT.GOV.MN цахим хуудсанд хийсэн үнэлгээтэй танилцаж, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан үнэлгээ алдсан арга хэмжээ тус бүрээр хариуцсан албан хаагчдыг хамруулж цахим хуудсанд мэдээлэл, шинэ цэсийг оруулсан болно.	70%
7		3.2. Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх.				Байхгүй	Тайлант хугацаанд АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичиг ирээгүй болно.	Үнэлэх боломжгүй
8		3.3. Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан				Байхгүй	Тайлант хугацаанд АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж, мөрдөгчийн мэдэгдэл, зөрчил арилгуулах албан бичиг ирээгүй болно.	Үнэлэх боломжгүй

		арга хэмжээг авч хэрэгжүүлэх.						
4. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх								
9		4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах.				Байхгүй	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэрээ, хэлэлцээрийг хянаж, дугаар өгч, авлигаас урьдчилан сэргийлэх агуулга бүхий заалтыг оруулж өгсөн болно.	100%
10		4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах.				Байхгүй	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэрээ, хэлэлцээрийг хянаж, дугаар өгч, авлигаас урьдчилан сэргийлэх агуулга бүхий заалтыг оруулж өгсөн болно.	100%
11		4.3. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх.				16 000 000	Ковид цар тахлын үед Авлигын эсрэг танхим сургалтыг Биеийн тамир,спортын салбарын удирдах ажилтнуудад 2021 оны 11 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд зохион байгуулсан болно.	70%
5. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах								
12		5.1. Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний талаар (И-Монголиад холбосон, автоматжуулсан				189 384 140	Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ын хэрэгжилтийн хүрээнд цахим сангийн сервер, тоног төхөөрөмжийг Үндэсний Дата төвд байршуулж, шилжүүлснээр салбарын мэдээллийн аюулгүй	70%

	үйлчилгээг оруулна) мэдээлэл.					байдлыг хангах, системийн хөгжүүлэлт хийх нөхцөл бүрдсэн. Салбарын мэдээллийн нэгдсэн цахим сангийн бүрдүүлэлт, ашиглалтын ажил хийгдэж байгаатай холбогдуулан олон талт хэрэглэгчдийн сургалт, нэвтрүүлэлтийг үе шаттай зохион байгуулан, спортын цол зэргийн цахим сангийн мэдээллийг цахим санд байршуулан холбогдох засвар үйлчилгээ, интерфэйсийн шийдэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, холбогдох шаардлагад нийцүүлэх ажиллаж байна. Цахим санд 21 спорт холбоодын холболтыг хийж холбогдсон холбоодын веб болон спортын цол олголт, тэмцээн, наадмын дэд системийн цэсийн төрийн үйлчилгээ үзүүлэх хөгжүүлэлтийн тогтмол хийгдэж байна.	
13	5.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн үйлчилгээний зохион байгуулалтыг өөрчилсөн, стандартыг шинэчилсэн талаар мэдээлэл.				800 000	Байгууллагын sport.gov.mn цахим сайтад албан хаагчдын нэр, албан тушаалыг тухай бүр шинэчлэн оруулдаг бөгөөд албан хаагчдын нэр, албан тушаал, хариуцсан нэгж, өрөөний дугаарыг кирилл монгол бичгээр хослуулан хаягжилтыг шинэчилсэн болно.	70%
14	5.3. Хүнд суртал, чирэгдлийг бууруулах, шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор өөрчлөлт оруулсан дүрэм, журмын талаар мэдээлэл.				Байхгүй	Дэлхийн допингийн эсрэг агентлагаас гаргасан жишиг загварын дагуу үндэсний допингийн эсрэг дүрмийн төслийг боловсруулан, спорт холбоодын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, sport.gov.mn цахим хуудсаар дамжуулж холбогдох саналыг авч нэгтгэн “Үндэсний допингийн эсрэг дүрэм”-ийн төсөл боловсруулсан. Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагаас санал авсны дараа Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр бэлтгэж байна. Биеийн тамир, спортын албарын “Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын дүрэм”, эрсдэлийн үнэлгээний суурь судалгаан дээр үндэслэн дотоод аудитын календарчилсан төлөвлөгөөг тус тус батлуулж ажилласан.	70%

15	5.4. Авлигын эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагаанд мониторинг, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан эсэх талаар мэдээлэл.				Байхгүй	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад төлөвлөгөөт дотоод аудит хийх, дүгнэлт зөвлөмжөөр ханган ажиллаж, Биеийн тамир, спортын албарын “Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын дүрэм”, эрсдэлийн үнэлгээний суурь судалгаан дээр үндэслэн дотоод аудитын календарчилсан төлөвлөгөөг тус тус батлуулж ажилласан.	70%
6. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах							
16	6.1. Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн албан ёсны цахим хуудсыг хөгжүүлж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь хүргэх.				20 000 000	Биеийн тамир, спортын салбарын мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор 5.5м урттай, 3м өндөртэй, лед гэрэл, шилэн хана, хавтан бүхий иж бүрэн хэрэгсэлтэй мэдээллийн тайз тохижуулалт хийгдэн ашиглалтад оруулсан байна. Байгууллагын албан ёсны <a href="http://www.sport.gov.mn">www.sport.gov.mn</a> цахим хуудсыг хөгжүүлсэн болно.	100%
17	6.2. Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах.				Байхгүй	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн болон агентлагийн урсгал үйл ажиллагаатай холбоотой 2 цахим хуудсанд нийт 244 удаагийн мэдээлэл (даргын тушаал, гэрээ) 401 баримтыг хавсарган байршуулсан. 11 сарын байдлаар шилэн дансанд 519 ширхэг нийт 13,3 тэрбум төгрөгийн зарлагын мэдээллийг байршуулсан. Орхигдуулсан мэдээлэл 0, хоцролт 1 байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө хоцрогдсон бөгөөд Засгийн газрын хэрэг эрхлэх газраас хуулийн хугацаанд батлагдаж ирээгүйгээс хоцролт үүссэн болно.	100%

